



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЛУУС СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 09 сарын 22 өдөр

Дугаар 1/12

Цагаан-Овоо

Дотоод хяналт шалгалтын ажлын хэсэг  
байгуулах тухай

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, Засгийн газрын 2011 оны “Нийтлэг журам батлах тухай” 311 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засаг даргын Тамгын газрын дотоод хяналт шалгалтын ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Ахлагч:	Засаг даргын орлогч
Гишүүн:	Сангууд хариуцсан нягтлан бодогч Нэгдүгээр багийн Засаг дарга Хөдөлмөр эрхлэлт халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Архив, бичиг хэргийн ажилтан

2. Байгууллагын дотоод хяналт шалгалт зохион байгуулах ажлын төлөвлөгөөг гарган батлуулж, хэрэгжилтийг тайлагнан ажиллахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ГАНЧИМЭГ

4823050023

Боловсруулсан: *Б. Түвшин*  
Хянасан: *с/л*  
Хувь: *2*